ХОВД АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН
2018-2019 ОНЫ САНХҮҮГИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

Нэг. Шалгалтын зорилго

Ховд аймгийн Засаг даргын баталсан 35/01/13 тоот удирдамжийн дагуу аймгийн Нийтийн номын сангийн 2018-2019 оны санхүүгийн үйл ажиллагаа, төрийн өмч хөрөнгийн ашиглалт зарцуулалт, хадгалалт, хамгаалалтын байдал, төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн хууль, тогтоомжийн хэрэгжилтэнд дүгнэлт өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, эрсдлээс урьдчилан сэргийлэх, цаашид авах арга хэмжээний санал боловсруулан ажиллахад оршино.

Хоёр. Шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа

Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга, Улсын ахлах байцаагч, дотоод ажилтан нар 2020 оны 09 сарын 28-наас ажлын 10 хоногийн хугацаанд хяналт, шалгалт хийлээ.

Гурав. Шалгалтанд хамрагдсан асуудал

Тус байгууллагын 2018-2019 оны санхүүгийн үйл ажиллагааг Монгол улсын санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн болон бусад хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар журмын хэрэгжилт, анхан шатны болон нягтлан бодох бүртгэл, үндсэн баримт материал, тайлан тэнцэлд тулгуурлан явуулав.

Дөрөв. Шалгалтанд хамрагдсан обьектын талаарх товч мэдээлэл

Тус байгууллага нь үйлчлүүлэгчдэд ээлтэй, соёлч боловсон үйлчилгээг хүргэж, уншигчдыг эрэлт хэрэгцээт ном, хэвлэлээр хангаж, ном унших сэдэл тэмүүллийг идэвхжүүлэн, орчин үеийн техник технологид суурилсан цахим номын сангаар үйлчлүүлэх боломжийг бүрдүүлэн, сум орон нутгийн номын санчдад арга зүйн заавар зөвлөгөө өгч материаллаг болон сэтгэлзүйн орчинг бүрдүүлэн ажиллах зорилгын хүрээнд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Номын сангийн тухай хууль, Соёлын тухай хууль, Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол улсын бусад хууль эрх зүйн актуудыг удирдлага болгон ажил үйлчилгээний чанар, бүтээмжийг дээшлүүлэн улсын төсвөөс батлагдсан төсвийн

санхүүжилтийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, эргэлтийн хөрөнгийг олж бэлтгэн иргэд, хүүхэд, залуучуудын хэрэгцээ, сонирхол, нийгмийн хэрэгцээнд тулгуурлан номын сангийн фондын баяжилтыг хийх, Электрон каталогийн хэрэглээг нэмэгдүүлж цахим орчинд ашиглах боломжтой болгох зэрэг зорилтуудыг дэвшүүлэн амжилттай ажиллаж иржээ.

Ховд аймгийн Нийтийн номын сан нь 1938 онд аймгийн Гэгээрлийн бага хурлын 211 тоот тогтоолоор “Уншлагын газар” нэртэйгээр 500 орчим боть номтой, нэг орон тоотой байгуулагдсан бол одоо тус номын сан нь ажлын 2 байр, уншлага үйлчилгээний 9 тасаг танхимтай, фондондоо 72 мянга гаруй боть номтой, 18 ажилтантай, нэг ээлжиндээ 280 хүнд зэрэг үйлчлэх хүчин чадал бүхий уншлагын тасаг танхимуудтай үйл ажиллагаагаа явуулж байна. Ажилчдын 80% мэргэжлийн боловсон хүчин ажилладаг.

Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Үндэсний бичиг соёл”-ын өдрийг зохион байгуулах, Соёл олон нийтийн ажлын хүрээнд Шувуун саарал богино өгүүллэгийн наадам, Ган үзэг яруу найргийн наадам зэргийг уламжлал болгон зохион байгуулж иржээ.

Шалгагдах хугацааны Төрийн сангийн 100160035011, нэмэлт санхүүжилтийн 100160035403 тоот дансны хөрөнгийн эрх захирагчийн нэгдүгээр гарын үсгийг захирал Т.Эрдэнэтуяа, 2-р гарын үсгийг нягтлан бодогч О.Чанцалмаа зурж, хяналт тавин ажиллаж ирсэн байна.

Тав. Төсвийн зарлага санхүүжилтийн талаар:

Тус байгууллага нь 2018 онд улсын төсвөөс 191512.2 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 2000.0 мянган төгрөг нийт 193512.2 мянган төгрөгийн санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр улсын төсвөөс 191512.2 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 2065.5 мянган төгрөг нийт 193577.7 мянган төгрөгийн төсөв бүрдүүлэн зарцуулсан байна.

Тус онд цалингийн зардалд 127392.5 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 15277.4 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 34722.4 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 1700.3 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 386.2 мянган төгрөг, шуудан холбооны зардалд 1395.2 мянган төгрөг, ном хэвлэлд 3511.1 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлсэд 1262.4 мянган төгрөг, багаж техник хэрэгсэлийн зардалд 1687.9 мянган төгрөг, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардалд 309.7 мянган төгрөг, урсгал засварт

3615.2 мянган төгрөг, томилолтын зардалд 324.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 1927.3 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

Оны эхэнд авлагын үлдэгдэлгүй байсан бөгөөд тайлант хугацаанд үүссэн авлагаа хугацаанд нь төлүүлж мөн үлдэгдэлгүй ажилласан байна.

Оны эхэнд 301.2 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байсан бол тайлант хугацааны эцэст 389.9 мянган төгрөг болж 88.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө оны эхэнд 906039.1 мянган төгрөг байсан бол оны эцэст 732441.0 мянган төгрөг болж, 173598.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд 33173.9 мянган төгрөгийн хөрөнгө шинээр худалдан авч, үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийж, 196714.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 407985.9 мянган төгрөгөөр хорогдуулсан байна. Мөн тайлант онд 31677.6 мянган төгрөгийн хөрөнгийн элэгдэл байгуулж, 114455.0 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй болсон байна.

Тус байгууллага нь 2019 онд улсын төсвөөс 216523.5 мянган төгрөг өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогоос 2500.0 мянган төгрөгөөр нийт 219023.5 мянган төгрөгийн санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 219023.5 мянган төгрөгийн төсөв бүрдүүлэн зарцуулсан байна.

Тус онд цалингийн зардалд 148704.9 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 18588.0 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 36828.8 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 1770.1 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 444.7 мянган төгрөг, шуудан холбооны зардалд 1056.9 мянган төгрөг, ном хэвлэлд 3296.9 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлсийн зардалд 630.3 мянган төгрөг, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардалд 309.7 мянган төгрөг, багаж техник, хэрэгслийн зардалд 809.1 мянган төгрөг, хөдөлмөр хамгаалалын хэрэгслийн зардалд 112.3 мянган төгрөг, урсгал засварын зардалд 2681.7 мянган төгрөг, томилолтын зардалд 391.3 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 2838.8 мянган төгрөг,ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулалын зардалд 500.0 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

Тус байгууллага оны эхэнд авлагагүй байсан бол тайлант хугацааны эцэст 82.7 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй болсон байна.

Оны эхэнд өглөгийн үлдэгдэл 389.9 мянган төгрөг байсан бол тайлант хугацааны эцэст өр төлбөрийг бүрэн барагдуулж, үлдэгдэлгүй болсон байна.

Үндсэн хөрөнгө оны эхэнд 732441.0 мянган төгрөг байсан бол тайлант хугацааны эцэст 796256.4 мянган төгрөг болж, 63815.4 мянган төгрөгөөр өссөн байна. Мөн тайлант онд 30694.3 мянган төгрөгийн хөрөнгийн элэгдэл байгуулж, 145149.3 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй болсон байна.

Зургаа. Өмнөх шалгалтын талаар:

2018, 2019 онуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчны чиглэлээр явуулсан аудитаар эрх бүхий албан тушаалтан өөртөө тушаал гаргаж ур чадварын нэмэгдэл олгосон, төрийн үйлчилгээний ажилтан болох бичиг хэргийн ажилтанд Засгийн газрын тогтоол зөрчиж, нууцын нэмэгдэл олгосон зөрчил илрүүлж, 333.2 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, 70.0 мянган төгрөгийн акт тогтоосон байна.

2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2018 оны жилийн ажлыг дүгнэн 2019 оны 01 сард олгохдоо үр дүнгийн нэмэгдлийг жилийн эцэст өглөгт тусгахгүйгээр олгосон, өөрийн орлогоо төрийн сангийн дансанд төвлөрүүлэлгүйгээр кассаар зарцуулсан нийт 1892.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, зөвлөмж хүргүүлсэн байна.

Долоо. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын талаар

1. Шалгалтаар байгууллагын захирал Э нь 2018 оны 06 дугаар сарын 07, 08-ны өдрүүдэд Ховд аймгийн Зэрэг, Чандмань сумдад томилолтоор ажилласан томилолтын дуудсан бичиг, тайлан, томилолтын хуудас байхгүй 33000 төгрөгийн томилолтын мөнгө авсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7, 20.1.1 дэх заалтуудыг

2. Захирал Э-д 2018 оны 08 дугаар сард ээлжийн амралттай байх хугацаанд 2 хоногийн цалин 54610 төгрөг давхардуулан олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, 55 дугаар зүйлийн 55.1 дэх заалтыг

3. Номын санч Н нь 2018 оны 01 дүгээр сард 3 хоногийн цалинтай чөлөө олгох өргөдөл гаргаж байгууллагын захирал ээлжийн амралтын хоногоос хасаж тооцохоор цохолт хийсэн байхад уг шийдвэрийг мөрдөлгүй 3 хоногийн цалин 67761 төгрөгийг илүү олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх заалтыг

4. Номын санч А-д 2018 оны 03 дугаар сард 4 хоногийн цалинтай чөлөө 107320 төгрөгийг, номын санч М-д 2 хоногийн цалинтай чөлөө 68188 төгрөгийг илүү олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх заалтыг

5. Нягтлан бодогч Ч-д 2019 оны 03 дугаар сараас ур чадварын нэмэгдэл олгох Даргын А/06 тушаал гарсан байхад ур чадварын нэмэгдэлийг олгохдоо нөхөж 20 хувь буюу 140825 төгрөгийг илүү олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.6 дахь заалтууд, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтыг

6. Архив албан хэрэг хангалтгүй хөтлөгдөж байгаа бөгөөд тушаал шийдвэрийг нөхөн гаргадаг, тушаал гарсан хугацаанаас өмнөх хугацаанд үйлчилэхээр тушаал гаргасан, тушаалын үндэслэх хэсэгт хуулийн хүчингүй болсон буруу зүйл заалтууд бичсэн байгаа зэрэг нь Архивын ерөнхий газрын даргын 2009 оны 68 дугаар тушаалаар батлсан “Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”-ыг

7. Хөдөлмөрийн дотоод журмын дагуу цалинтай чөлөө олгохдоо тушаал гаргаагүй, цалин бодож олгохдоо 2018 оны 02, 03 дугаар сараас бусад сард ажилчдын ажлын цагийн бүртгэл гаргаагүй нь Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7 дахь заалтуудыг

8. Засвар, сантехникийн ажил гүйцэтгүүлэхдээ гэрээ байгуулан ажиллуулж, тухайн аж ахуй нэгж, хувь хүмүүсээр ажлын тайлан гаргуулж, холбогдох баримтуудад үндэслэн ажлын хөлсийг шилжүүлээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.6 дахь заалтыг

Шалгалтаар нийт 471704 төгрөгийн төлбөр зөрчил илэрч, 471704 төгрөгийг орон нутгийн төсөвт оруулахаар шийдвэрлэж, улсын байцаагчийн 3 акт үйлдлээ.

Мөн Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын батлсан 35/03/09 тоот удирдамжийн дагуу тус байгууллагын 2015, 2016, 2017 оны санхүүгийн үйл ажиллагаанд 2018 оны 07 дугаар сард улсын ахлах байцаагч, улсын байцаагч 2 хүний бүрэлдэхүүнтэй хяналт шалгалт хийж тогтоосон улсын ахлах байцаагчийн 35/06/77, 35/06/81, 35/06/82 тоот актуудыг төлүүлэхээр болов.

Ес. Дүгнэлт:

Тус байгууллага нь санхүүгийн тайлангаа хуулийн хугацаанд нь гаргаж, зохих байгууллагаар баталгаажуулан тушааж, Монгол улсын Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж хэвшсэн байна.

Анхан шатны баримтын бүрдэл дутуу, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажлаагүй, цалинтай чөлөө олгохдоо байгууллагын дотоод журмыг мөрдөөгүй, албан томилолтын зардлыг холбогдох журам зөрчин олгосон зөрчлүүд байгааг арилган, холбогдох хууль журмын хэрэгжилтэнд анхаарч ажиллах нь зүйтэй.

Арав. Цаашид авах арга хэмжээний санал:

1. Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай хэмнэлттэй зарцуулах
2. Архив албан хэрэг хөтлөлтийн стандарт, дүрэм журмыг мөрдөх, тушаал шийдвэрийг үнэн зөв гаргах
3. Цалин хөлсийг олгохдоо ажилчдын ажлын цагийн тооцоог сар бүр гаргаж үнэн зөв тогтоох, цалин хөлсийг зохих журмын дагуу зөв бодох, тооцооллын алдаа гаргахгүй хариуцлагатай ажиллах.
4. Хөдөлмөрийн дотоод журмын дагуу цалинтай чөлөөг олгохдоо даргын тушаалаар баталгаажуулах
5. Засвар, үйлчилгээний ажил гүйцэтгүүлэхдээ гэрээ байгуулан ажиллаж, тухайн аж ахуй нэгж, хувь хүмүүсээр ажлын тайлан гаргуулж, холбогдох баримтуудыг бүрдүүлж хэвших

Шалгалтаар илэрсэн зөрчлийг дахин давтан гаргахгүй ажиллаж, актын төлбөрийг барагдуулж тайланг 2020 оны 12 дугаар сарын 15-ны дотор ирүүлэхийг даалгав.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБА